



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 583

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аудитын газрын харьяа Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлах боломжгүй болсон засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 60,000,000.00 /жаран сая/ төгрөгийн балансын үнэ, 59,166,666.43 /тавин есөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг дөчин гурван мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Л.Ламаачин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн
583 дугаар тогтоолын хавсралт

Үндэсний аудитын газрын харьяа Өвөрхангай аймаг дахь
Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ноосон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Ландкрузер-100, 00-38 УБӨ, арал №JTECJ09J405513191	2007/ 2007	898,3	60,000,000.00	59,166,666.43	833,333.57	1,000,000.00
	Нийт дүн			60,000,000.00 /жаран сая/	59,166,666.43 /тавин есөн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг дөчин гурван мөнгө/	833,333.57 /найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг тавин долоо мөнгө/	1,000,000.00 /нэг сая/